33.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 01 өдөр Дугаар 79 Улаанбаатар хот

Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5^1$.2 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Салбарын хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан төлөвлөгөөнд нийцүүлэн тухайн салбарын хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг баталж, хяналтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг салбарын хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4.Салбар хоорондын уялдаа холбоог хангаж, хяналт шалгалтыг давхардуулахгүй, бүртгэл, хяналтын удирдлагын нэгдсэн цахим системийг шинэчилж, хэвийн, аюулгүй байдлыг хангаж хариуцаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН

ШТА0609 9023010224 5498449

Засгийн газрын 2023 оны 03 дугаар
сарын 01 -ны өдрийн 79 дүгээр
тогтоолын хавсралт

ШТА0609 9023010224 5498449

# САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа | Хяналт шалгалтын байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | Төлөвлөгөөт шалгалт | | | | |
| 1. | Байгаль орчны хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуураар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 949 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | 2021 онд 1201 объектыг шалгаж, 862 объектод 10119 зөрчил илрүүлж, 16.0 хувийг арилгуулж, хууль сахин мөрдөлтийг 70 хувьтай хангуулж, 408 объектын эрсдэлийн түвшинг бууруулсан. 2022 онд төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй. | Төлөвлөгөөт шалгалтын гүйцэтгэлийг 100 хувь хэрэгжүүлнэ. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | I-IV улирал | БОАЖЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 2. | Барилга, хот байгуулалтын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 866 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | 2021 онд 2023 объектод төлөвлөгөөт шалгалт хийсэн. | Төлөвлөгөөт шалгалтын гүйцэтгэлийг 100 хувь хэрэгжүүлнэ. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | II-III улирал | БХБЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 3. | Боловсрол, шинжлэх ухааны салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 415 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | Хяналт шалгалт хийсэн объектын тоо 517 | Төлөвлөгөөт шалгалтын гүйцэтгэлийг 100 хувь хэрэгжүүлнэ. | II-IV улирал | БШУЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | | Зөрчил арилгуулалт 68 хувь | Зөрчил арилгуулалт 73 хувь | | |
| | | | | Хууль сахин мөрдөлтийн түвшний өсөлт 73 хувь | Хууль сахин мөрдөлтийн түвшний өсөлт 75 хувь | | |
| 4. | Цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 336 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл | 97 хувь | 100 хувь | II-III улирал | БШУЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Хууль сахин мөрдөлтийн түвшин | 78 хувь | 82 хувь | | |
| 5. | Геологи, уул уурхай, газрын тосны салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 753 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, | 2021 онд 449 объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөсөнөөс 170 объектод хяналт шалгалт хийгдсэн. Хяналт шалгалтын | Шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг 10.0 хувиар нэмэгдүүлсэн | II-III улирал | УУХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арилгуулалтын хувь, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | гүйцэтгэл 61.92 хувьтай байна. Шалгалтад хамрагдсан объектын эрсдэл үүсэх магадлал өмнөх оноос 58 объектоор буурсан байна. | байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. | | байгууллага, нэгж |
| 6. | Зам, тээврийн салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 375 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | 2022 онд төлөвлөгөөт 16 шалгалтад давхардсан тоогоор 80 хуулийн этгээд хамрагдсан. Илэрсэн зөрчил дутагдлын 86.15 хувийг арилгуулсан. | Төлөвлөгөөт шалгалтын гүйцэтгэлийг 100 хувь хэрэгжүүлнэ. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | I-III улирал | ЗТХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 7. | Соёлын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 95 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Зөрчил, дутагдал арилгалтын хувь | 35хувь (2021 онд 164 объектод 3300 зөрчил илэрснээс арилгасан хувь) | 80 хувь (Зөрчил арилгалтын хувь) | II-III улирал | СоЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Тухайн жилд эрсдэлийн ангилал буурсан объектын хувь | 30 хувь (2021 онд эрсдэлийн ангилал буурсан объектын хувь) | 60 хувь (Эрсдэлийн ангилал буурсан объектын хувь) | II-III улирал | |
| 8. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2413 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Хяналт шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | 2022 онд 641 объектод хяналт шалгалт хийж, 3486 зөрчил илрүүлсний 942 буюу 27 хувийг арилгуулсан. 437 объектын эрсдэлийн түвшинг бууруулсан. | Шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшинг 10.0 хувиар нэмэгдүүлсэн байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. | II-III улирал | ХНХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 9. | Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3349 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Хяналт шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | 2021 онд шалгалтад 3970 объект хамрагдахаас 62.0 хувь хамрагдсан. | Төлөвлөгөөт шалгалтын гүйцэтгэлийг 100 хувь хэрэгжүүлнэ. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | I-III улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 10. | Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 153 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Хууль сахин мөрдөлт (хувь) | 75.68 хувь | 78 хувь | I-IV улирал | ЦХХХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Эрсдэл үүсэх магадлалын бууралт (хувь) | 30.2 хувь | 28.3 хувь | | |
| 11. | Эрүүл мэндийн салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3352 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Объектын хамралт | 90.7 хувь | 100 хувь | I-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт |
| | | | Эрсдэлийн түвшин | Их-1031 буюу 30.6 хувь | Их-25.6 хувь | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дунд-2335 буюу 69.3 хувь | Дунд-64.3 хувь | | шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Хууль тогтоомжийн хэрэгжилт | 71.3 хувь | 75.0 хувь | | |
| 12. | Эрчим хүчний салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 224 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Хяналт шалгалт хийсэн объектын тоо, Эрсдэлийн ангилал буурсан объектын хувь | 2021 онд төлөвлөгөөт шалгалтад 350 объектыг хамруулсан байна. | Төлөвлөгөөт шалгалтын гүйцэтгэлийг 100 хувь хэрэгжүүлнэ. Эрсдэлийн ангилал буурсан объектын түвшинг тодорхойлно. | I-III улирал | ЭХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 13. | Стандарт хэмжил зүйн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 283 объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | Хэмжил зүйн хяналтаар: 294 объектыг шалгалтад хамруулж, 243 объектод 1752 зөрчил илрүүлснээс 18.6 хувийг арилгуулсан. Илэрсэн зөрчилд 4.6 сая.төгрөгийн торгууль ногдуулж, 100 хувь барагдуулсан. 189 объектын эрсдэлийн түвшнийг бууруулсан. | Шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшнийг 10.0 хувиар нэмэгдүүлсэн байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Объектын эрсдэлийн түвшнийг бууруулсан байна. | I-IV улирал | СХЗГ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Урьдчилан сэргийлэх шалгалт | | | | |
| 14. | Уурын болон усан халаалтын зуухны яндангийн утаанд агуулагдах агаар бохирдуулагч бодис стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | 15.0 сая.төг | Стандартын шаардлага хангасан халаалтын зуух (хувиар) | Хэмжилтийн багажгүйн улмаас өмнө нь хийгдээгүй 0 хувь | Стандартын шаардлага хангасан халаалтын зуухны тоог 10 хувиар нэмэгдүүлнэ. | I-IV улирал | БОАЖЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 15. | Нийслэлийн агаарын чанарын бүсэд агаар бохирдуулагч эс үүсвэр бүхий объектуудад урьдчилан сэргийлэх шалгалт хийх | 20.0 сая.төг | Агаар бохирдуулагч эх үүсвэр бүхий объектын бууралт (хувиар) | 2022 онд агаар бохирдуулагч 2187 эх үүсвэрт шалгалт хийсэн. | Агаар бохирдуулагч эх үүсвэр бүхий объектын тоог 5 хувиар бууруулж, стандартын шаардлагад нийцүүлсэн байна. | I-IV улирал | БОАЖЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 16. | Аялал жуулчлалын бааз, ШТС-уудын ариун цэврийн байгууламж стандартын шаардлага хангаж буй эсэхэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай жуулчны баазын эзлэх хувь | 2022 оны байдлаар 30 хувь нь жуулчны бааз, 90 хувь ШТС-ууд нүхэн жорлонтой байна. | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай Аялал жуулчлалын бааз, ШТС-ын тоог 50 хувьд хүргэсэн байна | I-IV улирал | БОАЖЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 17. | Ой, байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэх, худалдаалах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | 10.0 сая.төг | Хяналт шалгалтын гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар), Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | 2022 онд байгалийн нөөц баялгийн хууль бус ашиглалттай холбоотой 336 зөрчлийг илрүүлсэн. Хууль сахин мөрдөлтийн түвшин 64.4 хувь, улсын байцаагчийн шийдвэр 98.2 хувь биелсэн. | Төлөвлөсөн хяналтуудыг хийсэн байна. Хууль сахин мөрдөлтийн түвшинг 5 хувиар нэмэгдүүлнэ. Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг 100 хувьтай хангуулна. | I-IV улирал | БОАЖЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 18. | Ан агнах, барих, худалдах, худалдаалах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | 15.0 сая.төг | Хяналт шалгалтын гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | 2022 онд байгалийн нөөц баялгийн хууль бус ашиглалттай холбоотой 336 зөрчлийг илрүүлсэн. Хууль сахин мөрдөлтийн түвшин 64.4 хувь, улсын байцаагчийн шийдвэр | Төлөвлөсөн хяналтуудыг хийсэн байна. Хууль сахин мөрдөлтийн түвшинг 5 хувиар нэмэгдүүлнэ Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг бүрэн | I-IV улирал | БОАЖЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 98.2 хувь биелсэн. | хангуулна. | | |
| 19. | Техникийн ашигласан тос, хаягдал аккумляторыг цуглуулах, хадгалалт, тээвэрлэлт, устгалтын байдалд холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх шалгалт хийх | 25.0 | Импортоор орж ирсэн болон хаягдал аккумляторын тоон судалгаа, хаягдал тосны ашиглалт, хадгалалтын тоон мэдээлэл, хөрсний бохирдлын шинжилгээний үзүүлэлтээр | Улсын хэмжээнд хаягдал аккумлятор дахин боловсруулах, хаягдал тос боловсруулах зөвшөөрөлтэй тус бүр 4 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. | Шинжилгээт шалгалтын дүнд үндэслэн цаашид бодлогын хэмжээнд асуудлыг шийдвэрлэх талаар санал, дүгнэлтийг гаргаж, холбогдох газарт хүргүүлсэн байна. | I-IV улирал | БОАЖЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 20. | Арьс шир, ноос ноолуур, мах болон өлөн боловсруулах үйлдвэрүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжуудын цэвэршүүлсэн бохир усанд урьдчилан сэргийлэх шалгалтыг хийх | 10.0 | Холбогдох стандартын үзүүлэлтээр | Нийслэл болон 16 аймгийн 44 цэвэрлэх байгууламжаас стандартын шаардлага хангаж байгаа цэвэрлэх байгууламж 26, шаардлага хангахгүй 12 байна. 2021 онд цэвэрлэгээний дундаж түвшин 60.8 хувьд 1.4 хувь дээшилсэн байна. | Бохир усны цэвэрлэгээний түвшинг 4 хувь нэмэгдүүлж 63.4 хувьд хүргэнэ. (цэвэрлэгээний дундаж түвшин ) | I-IV улирал | БОАЖЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 21. | Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр болон өргөтгөл, шинэчлэл хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шинээр баригдаж байгаа барилга, барилгын материал болон өргөх байгууламжийн тоо,<br>Инженерийн шугам сүлжээний у/м,<br>Зөрчил арилгуулалтын хувь | 2023 барилга байгууламж | Төлөвлөсөн хяналтуудыг хийсэн байна. Хууль сахин мөрдөлтийн түвшинг 5 хувиар нэмэгдүүлнэ. Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг хангуулна. | II-IV улирал | БХБЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 22. | Улсын хэмжээнд барилга байгууламжид хэрэглэж байгаа бетон зуурмаг, арматурын чанар байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх. | Улсын төсөв | Урьдчилан сэргийлэх шалгалт (объектын тоо),<br>Тухайн жилийн эрсдэл үүсэх магадлалын бууралт, хувь | Өмнө нь хийгдээгүй | Төлөвлөсөн хяналтуудыг хийсэн байна. Хууль сахин мөрдөлтийн түвшинг 5 хувиар нэмэгдүүлнэ. Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг хангуулна. | II-IV улирал | БХБЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 23. | Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа орон сууц, олон нийт, иргэний барилга байгууламжийн ашиглалт, техникийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Ашиглаж байгаа барилга байгууламж, лифт, эскалаторын тоо, чанар | 9385 барилга байгууламж | Төлөвлөсөн хяналтуудыг хийсэн байна. Хууль сахин мөрдөлтийн түвшинг 5 хувиар нэмэгдүүлнэ. Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг хангуулна. | II-IV улирал | БХБЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 24. | Хот, суурин газрын инженерийн бэлтгэл арга хэмжээний ажлын чанар, ашиглалтын төлөв байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Үерийн усны шугам сүлжээ, инженерийн барилга байгууламжийн тоо, чанар | 126 км үерийн усны шугам сүлжээ, инженерийн барилга байгууламж | Төлөвлөсөн хяналтуудыг хийсэн байна. Хууль сахин мөрдөлтийн түвшинг 5 хувиар нэмэгдүүлнэ. Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг хангуулна. | II-IV улирал | БХБЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 25. | ЕБС, МСҮТ, коллеж, политехник коллеж, их, дээд сургуулийн дотуур байрны үйл ажиллагаа, стандартын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Хамрагдсан объект (хувиар) | 0 хувь | 100 хувь | I-IV улирал | БШУЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Зөрчил арилгуулалтын хувь | 0 хувь | 73 хувь | | |
| 26. | МСҮТ-ийн дэргэдэх сургалтын төвийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Хяналт шалгалт хийсэн объектын тоо | 0 | 29 | I-IV улирал | БШУЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын |
| | | | Зөрчил арилгуулалтын хувь | 0 хувь | 73 хувь | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллага, нэгж |
| 27. | Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2023-2024 оны хичээлийн жилийн бэлтгэл, үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Объектын хамралтын хувь (боловсролын хяналт)<br>Объектын хамралтын хувь (ЭАХХХ)<br>Зөрчил арилгуулалтын хувь<br>Хууль тогтоомжийн хэрэгжилт | 35 хувь<br>95 хувь<br>48.5 хувь<br>72.5 хувь | 40 хувь хүртэл<br>95 хувь<br>53.5 хувь<br>73.0 хувь | III-IV улирал | БШУЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 28. | "Сургуулийн өмнөх боловсрол болон бага боловсролын багш хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд урьдчилсан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Хамрагдсан объект (хувиар)<br>Зөрчил арилгуулалтын хувь<br>Шаардлага хангасан хөтөлбөрийн тоо | 0 хувь<br>0 хувь<br>0 | 50 хувь<br>73 хувь<br>- | I-IV улирал | БШУЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 29. | Геологи, хайгуулын судалгаанд цацрагийн үүсгүүр ашиглаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (тоо)<br>Илэрсэн зөрчил арилгуулалт (хувь) | - | 5<br>100 хувь | II-IV улиралд | БШУЯ аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 30. | Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг илрүүлэх урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Илрүүлсэн цацрагийн үүсгүүр (тоо) | - | - | II-IV улиралд | БШУЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 31. | Цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын тунд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Нийт хяналтад хамрагдсан цацрагтай ажиллагчид (хувь),<br>Илэрсэн зөрчил арилгуулалт (хувь) | 100 хувь | 100 хувь | II-IV улиралд | БШУЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 32. | Улсын хэмжээнд цацрагийн дэвсгэр түвшинд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Хэмжилт гүйцэтгэсэн цэг, Сар бүр ирүүлсэн хэмжилтийн мэдээ (тоо) | Хэмжилт гүйцэтгэсэн цэг 34, Ирүүлсэн хэмжилтийн мэдээ 12 | Хэмжилт гүйцэтгэсэн цэг 35, Ирүүлсэн хэмжилтийн 12 удаагийн мэдээ | II-IV улиралд | БШУЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 33. | Импортын хүнсний бүтээгдэхүүнд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Тухайн жилд шинжилгээнд хамруулсан хүнсний бүтээгдэхүүн (дээжийн тоо) | Хүнсний бүтээгдэхүүний 289 дээж | - | II-IV улиралд | БШУЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 34. | Авто зам, замын байгууламжийн хариуцагч аж ахуйн нэгж байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | Авто зам хариуцагч 32 аж ахуйн нэгж байгууллагад "Авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдлыг хангаж ажиллах тухай" зөвлөмж хүргүүлсэн. | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилт 80 хувьтай хэрэгжсэн байна. | III улирал | ЗТХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 35. | Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар, шинэчлэлт, ээлжит засварын ажлын зөвлөх, гүйцэтгэгч байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан | Үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх сэдвээр уулзалт зохион байгуулсан. | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилт 80 хувьтай хэрэгжсэн байна. | III улирал | ЗТХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шийдвэрийн биелэлт | | | | байгууллага, нэгж |
| 36. | Ахуйн хог хаягдал тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | Хяналт шалгалт хийх хууль, эрх зүйн орчин, нөхцөл бүрдсэн. | Хяналт шалгалт хийсэн байна. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилт 80 хувьтай хэрэгжсэн байна. | III улирал | ЗТХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 37. | Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | Хяналт шалгалт хийх хууль, эрх зүйн орчин, нөхцөл бүрдсэн. | Хяналт шалгалт хийсэн байна. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын баримт бичгийн хэрэгжилт 80 хувьтай хэрэгжсэн байна. | III улирал | ЗТХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 38. | Соёл, урлагийн байгууллагын эдэлбэр газрын гэрчилгээ, кадастрын зөрчлийг таслан зогсоох урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв 15.0 сая.төг | Эдэлбэр газрын гэрчилгээ, кадастрт бүртгэлгүй зөрчил арилгалтын хувь | 0 хувь | 70 хувь (Зөрчил арилгалтын хувь) | II -III улирал | СоЯ, БХБЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 39. | Соёлын төв, соёлын ордны орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий стандарт MNS 6981:2022-ын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв 2.5 сая.төг | Зөрчил, дутагдал арилгалтын хувь | 0 хувь | 50 хувь (Зөрчил арилгалтын хувь) | II улирал | СоЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 40. | Мэргэжлийн урлагийн байгууллагын орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага стандарт MNS 6476:2014-ын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв 2.5 сая.төг | Зөрчил, дутагдал арилгалтын хувь | 0 хувь | 50 хувь (Зөрчил арилгалтын хувь) | I-II улирал | СоЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 41. | Түүх соёлын хөдлөх дурсгалын 2023 онд хийх улсын тооллогод урьдчилан сэргийлэх шалгалт хийж, Салбар комиссын тайланд дүгнэлт гаргах | Улсын төсөв 5.0 сая.төг | Дүгнэлтийн тоо | 44 (2018 оны дүгнэлтийн тоо) | 40 (Дүгнэлтийн тоо) | II-IV улирал | СоЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 42. | Гадаадад үзэсгэлэн гаргах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, зөрчлийг таслан зогсоох | - | Зөрчил, дутагдал арилгалтын хувь | 100 хувь (Нийт илэрсэн зөрчил арилгалтын хувь) | 100 хувь (Нийт илэрсэн зөрчил арилгалтын хувь) | I-IV улирал | СоЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 43. | Соёл, урлагийн байгууллагын барилга шинээр барих болон сэргээн засварлалт хийх явцад урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв 5.0 сая.төг | Зөрчил, дутагдал арилгалтын хувь | 0 хувь | 50 хувь (Зөрчил арилгалтын хувь) | II-III улирал | СоЯ, БХБЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 44. | Соёл, урлагийн байгууллагуудын цахим шилжилтийн явцад урьдчилан сэргийлэх шалгалт хийх | - | Санал хэрэгжилтийн хувь | 0 хувь | 50 хувь (Хэрэгжсэн саналын хувь) | II-III улирал | СоЯ, БХБЯ, аймаг, нийслэлийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 45. | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байрны аюулгүй ажиллагаа, тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | Тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэгч 9 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийсэн. | Шалгалтаар илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулж, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | II-III улирал | УУХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 46. | Ашигт малтмалыг хууль бусаар олборлох эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах журмын зөрчлийн илрүүлэлт, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | Хууль бусаар олборлох зөрчлийн илрүүлэлт 2021 оноос 20 хувь сайжирсан байна. | Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах журмын хэрэгжилтийг хангуулна. | II-III улирал | УУХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 47. | Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | - | Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. | II-III улирал | УУХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 48. | Улсын комиссоор ашиглалтад хүлээлгэн өгөлгүйгээр ашиглаж байгаа болон зориулалтын бус байр, талбайд зөвшөөрөлгүйгээр ашиглаж байгаа зөөврийн шатахуун түгээх станцын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Хууль сахин мөрдөлтийн түвшин, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | - | Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. | II-III улирал | УУХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 49. | Барилга, замын салбарт хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | Хөдөлмөрийн хяналт: Нийт 1376 байгууллага, иргэн хамрагдсан. Шалгалтаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Барилгын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны норм, дүрэм журмыг хэрэгжүүлээгүй нийт 4545 зөрчил илрүүлсний 1818 буюу 40.0 хувийг шалгалтын хугацаанд арилгуулсан. Хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр шалгалт хийгдэж байгаагүй. | Шалгалтаар илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулж, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | II-IV улирал | ХНХЯ, БХБЯ, ХХҮЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ХХҮГ, дүүргүүдийн ХХҮХ |
| 50. | Уул уурхай, тээвэр, хүнд үйлдвэрийн салбарт хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналт: Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр шалгалт хийгдэж байгаагүй. | Шалгалтаар илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулж, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | II-IV улирал | ХНХЯ, УУХҮЯ, ЗТХЯ, ХХҮЕГ, аймаг, нийслэлийн ЗДТГ, ХХҮГ, дүүргүүдийн ХХҮХ |
| 51. | Морь унаач хүүхдийн аюулгүй байдалд | Улсын | "Үндэсний морин уралдааны | 2022 онд 17378 хүүхэд даатгалд | Шалгалтаар илэрсэн | II-IV | ХНХЯ, ГБХЗХГ, |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх шалгалт хийх | төсөв | морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага" MNS 6264:2018 стандартын хэрэгжилт, эцэг, эх, даатгалын байгууллага, морь уяачдын хоорондын гурвалсан гэрээ, 8-аас доош насны хүүхэд морь унаагүй байх | хамрагдсан, 16440 хүүхэд гурвалсан гэрээ байгуулсан, 7-оос дээш насны 17450 хүүхэд морь унасан. | зөрчлийг 100 хувь арилгуулж, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | улирал | ХХҮЕГ, аймаг, нийслэлийн ХХҮГ, дүүргүүдийн ХХҮХ, аймаг, нийслэлийн ГБХЗХХ |
| 52. | Боловсруулах үйлдвэр, уул уурхай, барилгын салбарт "Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Жагсаалтад дурдагдсан ажлын байранд насанд хүрээгүй хүүхэд ажиллуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо | Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр шалгалт хийгдэж байгаагүй. | Шалгалтаар илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулж, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | I-IV улирал | ХНХЯ, ГБХЗХГ, ХХҮЕГ, аймаг, нийслэлийн ХХҮГ, дүүргүүдийн ХХҮХ, аймаг нийслэлийн ГБХЗХХ |
| 53. | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх итгэмжлэгдсэн байгууллагуудын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | Суурь үзүүлэлт байхгүй | Шалгалтаар илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулж, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | II улирал | ХНХЯ, ХХҮЕГ |
| 54. | 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэд, мөн хугацаанд Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгон давхардуулан авч байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Тэтгэврийн тогтоолт, олголтын зөрчлийн бууралт, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | 2022 онд Нийгмийн даатгалын Тэтгэврийн даатгалын санд хийсэн урьдчилан сэргийлэх шалгалтаар Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байсан 2 иргэн Нийгмийн даатгалын сангаас 2804.2 мянган төгрөгийн тэтгэвэр авсан зөрчлийг илрүүлж улсын байцаагчийн актаар санд нөхөн төлүүлсэн. | Хууль бусаар олгосон тэтгэврийг нийгмийн даатгалын санд буцаан төвлөрүүлж, иргэдэд дутуу олгосон тэтгэврийг нөхөн олгуулсан байна. | 3-4 дүгээр сард | ХНХЯ, НДЕГ, аймаг, дүүргийн НДХ |
| 55. | Нийгмийн халамжийн байгууллагуудын Нийгмийн халамжийн санд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Сангуудын бүрдүүлэлт, зарцуулалтын зөрчлийн бууралт, Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтын зөрчлийн бууралт, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | 2018 онд Нийгмийн халамжийн санд хийсэн шалгалтаар Нийгмийн халамжийн тэтгэвэр, амралт, сувиллын эрхийн үнийн хөнгөлөлтийг илүү, дутуу олгосон, хүнс, тэжээлийн дэмжлэг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, насны хишгийг илүү олгосон зэрэг нийт 65.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулсан. | Халамжийн тэтгэврийн сангаас хууль бусаар олгосон тэтгэврийг санд буцаан төвлөрүүлж, иргэдэд дутуу олгосон тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн олгуулсан байна. | II улирал | ХНХЯ, НДЕГ, аймаг, дүүргийн НДХ |
| 56. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021-2022 оны бүрдүүлэлт, зарцуулалтад төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Сангуудын бүрдүүлэлт, зарцуулалтын зөрчлийн бууралт, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт | ХЭД сангаас санхүүгийн дэмжлэгээр эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийг хугацаандаа төлөөгүй, ажил олгогчид олгох урамшууллыг илүү олгосон, нийтийг хамарсан ажлын хөлсийг ахмад настанд олгосон, сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан зэрэг 549.0 сая | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан 7 хөтөлбөрөөс 3 хөтөлбөрийг сонгон хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтын дүнг үндэслэж холбогдох арга хэмжээ авсан байна. | IV улирал | ХНХЯ, НДЕГ, аймаг, дүүргийн НДХ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төгрөгийн, нийт 614.3 сая төгрөгийн зөрчил дутагдалд улсын (ахлах) байцаагчийн акт тогтоож холбогдох сангуудад буцаан төлүүлэхээр шийдвэрлэсэн | | | |
| 57. | ХБАБХТХ-ийн 18.1, ЗГҮАХ-ийн 4.3.13 Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах (Цагаан сар, Хүүхдийн баяр, Наадам, Шинэ жил) | Улсын төсөв | Зөрчил арилгуулалтын хувь (ХЧСХ) | 58 хувь | Эхний хагас жилд 60 хувь Сүүлийн хагас жилд 65 хувь | I-IV улирал | ХХААХҮЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Зөрчил арилгуулалтын хувь (ЭАХХХ) | 69.4 хувь | 71.0 хувь | | |
| 58. | Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний хангамж, нийлүүлэлт, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Зөрчил арилгуулалтын хувь | 60 хувь | Сүүлийн хагас жилд 70 хувь | III улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 59. | Мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдэд импортлогч орны тавьж байгаа мал эмнэлэг, ариун цэврийн шаардлага болон чанар аюулгүй байдлыг хангуулахад урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Зөрчил арилгуулалтын хувь | 60 хувь | Эхний хагас жилд 62 хувь Сүүлийн хагас жилд 65 хувь | I-IV улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 60. | Бялуу, бялуун бүтээгдэхүүний хүнсний нэмэлтийн импортлолт, худалдаалалт, хэрэглээний байдалд тандалт судалгаа хийх | Улсын төсөв | Хэрэглэж буй хүнсний нэмэлт нь Монгол Улсад бүртгэлтэй эсэх (Тийм-1, үгүй-0) | - | Сүүлийн хагас жилд 1 | I-IV улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 61. | Ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл, хорио цээр, чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Холбогдох стандартын шаардлага хангасан дээжийн хувь | 90 хувь | Сүүлийн хагас жилд 93 хувь | I-IV улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 62. | Бэлчээрийн ургамал хамгааллын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Хамрагдсан аймгийн тоо | - | Эхний хагас жилд 3 Сүүлийн хагас жилд 5 | I-IV улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 63. | 2023 онд тариалах үрийн чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх (стандартын шаардлага хангасан үрээр тариалалт хийх) | Улсын төсөв | Стандартын шаардлага хангасан үрээр тариалалт хийсэн хувь | 65 хувь | Эхний хагас жилд 75 хувь | II-III улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 64. | Таримлын үрийн чанар, үрийн нөөцийн бүрдүүлэлт, хүнсний улаан буудайн чанарт хяналт-шинжилгээ хийх (2024 онд стандартын шаардлага хангасан таримлын үрийн нөөцийг бүрдүүлэх, хүнсний улаан буудайн чанар, аюулгүй байдал, хангамж) | Улсын төсөв | Дотоодод үйлдвэрлэсэн таримлын үрийн хэмжээ хувиар | 70 хувь | Сүүлийн хагас жилд 80 хувь | III-IV улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 65. | Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малын эм хангамжийн байгууллагад стандартын хэрэгжилт, мал эмнэлгийн арга хэмжээ, ажил үйлчилгээ, эмийн чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалтад хамрагдсан объектын тоо, Гүйцэтгэлийн хувь | Мал эмнэлгийн нэгжийн тоо 940, Малын эмийн үйлдвэр 15, Малын эм хангах нийлүүлэх байгууллага 110, Малын эмийн сан 238 | Эхний хагас жилд 1.1303 2. - Сүүлийн хагас жилд 1. - 2. 100 хувь | II-IV улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 66. | Ноос, ноолуур, арьс шир бэлтгэх, боловсруулах үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүний гарал, үүсэл, чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Хамрагдсан объектын тоо | Ноос, ноолуурын үйлдвэр 32, Арьс ширний үйлдвэр 33 | Сүүлийн хагас жилд 65 | III улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 67. | Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалт, өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэлт, нөөцлөлт, хадгалалтад урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Өвс тэжээл бэлтгэлийн хувь, Аюулгүйн нөөц бэлтгэлийн хувь | 1. 84.5 хувь 2. 94 хувь | Сүүлийн хагас жилд 1. 85 хувь 2. 95 хувь | III-IV улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 68. | Үхэр сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Ялган тэмдэглэсэн үхрийн тоо, Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн үхрийн тоо | - | Эхний хагас жилд 1. 2.7 сая толгой үхэр 2. 2.7 сая толгой үхэр Сүүлийн хагас жилд 1. 2.7 сая толгой үхэр 2. 2.7 сая толгой үхэр | II-IV улирал | ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 69. | Гадаадын зээл тусламж, төсөл, хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Зөрчил арилгуулалт (хувь) | 65 хувь | 78 хувь | I-IV улирал | ЦХХХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 70. | Хот, суурины ус хангамж, ариутгах татуурга, ашиглалтын тухай хуулийн 17.9 Ундны усны эх үүсвэр, ус түгээх байр, хэрэглэгчийн түвшинд усны чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шинжилсэн дээжийн тоо | 2965 | 2965 | I-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Стандартын шаардлага хангаагүй дээжийн хувь/нян судлал | 8.9 хувь | 8.5 хувь | | |
| 71. | Хот, суурины ус хангамж, ариутгах татуурга, ашиглалтын тухай хуулийн 17.9 Туул голын усанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шинжилсэн дээжийн тоо | 30 | 30 | III-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, |
| | | | Шаардлага хангаагүй дээжийн хувь | 16.7 хувь | 16.0 хувь | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэгж |
| 72. | ОЭМҮХөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.7<br>Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн түвшинд шинжилгээтэй хяналт шалгалтыг зохион байгуулах | Улсын төсөв | Шинжилсэн дээжийн тоо | 118 | 60 | II-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Шаардлага хангаагүй дээжийн хувь | 65.0 хувь | 65.0 хувь | | |
| 73. | ЕБСХҮҮТХ-ийн 12.1<br>Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны илчлэг, шимт бодисын хэмжээг тодорхойлох шинжилгээтэй урьдчилан сэргийлэх шалгалт зохион байгуулах | Улсын төсөв | Хоолны илчлэгийн хэмжээ | 1972.4 | Хяналт шалгалтаар тогтоосон байна. | II-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Хоолны шимт бодисын хэмжээ (уураг, өөх тос, нүүрс ус) | Уураг – 76.1<br>Өөх тос – 60.7<br>Нүүрс ус – 281.9 | | | |
| 74. | ЭАТХ-ийн 4.4<br>Хот, суурин газрын хөрсний бохирдлын түвшин тогтоох шинжилгээтэй хяналт зохион байгуулах | Улсын төсөв | Шинжилсэн дээжийн тоо | 332 | 200 | II-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Дунд, их бохирдолтой дээжийн эзлэх хувь | Дунд – 24 хувь<br>Их – 9 хувь | Дунд – 23 хувь<br>Их – 8 хувь | | |
| 75. | ЭАТХ-ийн 5.3<br>Барилга байгууламж барих газар олголт зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргах | Улсын төсөв | Хамруулсан объектын тоо | 1438 | Хүсэлтийн дагуу | I-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Шаардлага хангасан хувь | 97 хувь | | | |
| 76. | ЭАТХ-ийн 8.2<br>Түүхий эд, бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэлийг экспортлох, импортлох хүсэлтийн дагуу эрүүл ахуйн дүгнэлт гаргах | Улсын төсөв | Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | - | 100 хувь | I-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 77. | ТХТХ-ийн 6.1<br>Тамхи, тамхин бүтээгдэхүүний хорт бодисын агууламж, чанар, аюулгүй байдалд эрүүл мэндийн дүгнэлт гаргах | Улсын төсөв | Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | 100 хувь | 100 хувь | I-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 78. | ТТХТХ-ийн 20.2, ЗГҮАХ-ийн 4.3.13<br>Гадаад орны болон төр, засгийн тэргүүн, зочин төлөөлөгчдийн айлчлалын үед хоол, хүнсний аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт зохион байгуулах | Улсын төсөв | Шийдвэрлэлтийн хувь (ЭАХХХ) | 100 хувь | 100 хувь | I-IV улирал | ЭМЯ, ХХААХҮЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | 1. Хүнсний аюулгүй байдлын хангасан эсэх (Тийм-1, Үгүй-0)<br>2. Хоолноос шалтгаалсан хордлогот халдвар гарсан эсэх (Тийм-1, Үгүй-0) (ХЧСХ) | 1. 1 2. 0 | Эхний хагас жилд 1. 1, 2. 0<br>Сүүлийн хагас жилд 1. 1, 2. 0 | Тухай бүр | |
| 79. | ЭАТХ-ийн 17.1, ЗГҮАХ-ийн 4.3.13<br>Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах | Улсын төсөв | Зөрчил арилгалтын хувь | 100хувь | 100хувь | II-III улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Объектын хамралтын хувь | Их - 3.03хувь<br>Дунд - 60.1хувь<br>Бага - 36.4хувь | Эрсдэлийн түвшин, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авч ажилласан байна. | | |
| | | | Хууль тогтоомжийн хэрэгжилт | 69.3 хувь | 72.0 хувь | | |
| 80. | ХБАБХТХ-ийн 6.5, ЗГҮАХ-ийн 4.3.13<br>Нялх, балчир, бага насны болон | Улсын төсөв | Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | 100 хувь | 100 хувь | I-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулахаас өмнө хүсэлтийн дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах | | | | | | Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 81. | ХБАБХТХ-ийн 6.5, ЗГҮАХ-ийн 4.3.13 Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулахаас өмнө урьдчилсан хяналт хийж дүгнэлт гаргах | Улсын төсөв | Хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь | 100хувь | 100хувь | I-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 82. | НБХХТХ-ийн 18.1.1, ЗГҮАХ-ийн 4.3.13 Нялх, балчир хүүхдийн хүнсний найрлага, сав баглаа, боодол, шошгод урьдчилан сэргийлэх шалгалт зохион байгуулах | Улсын төсөв | Хууль тогтоомжийн хэрэгжилт | 82.5хувь | 83.0хувь | I-IV улирал | ЭМЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| | | | Зөрчил арилгуулалтын хувь | 65.7хувь | 67.0хувь | | |
| 83. | Эрчим хүчний системийн 6-35 кВ, 110-220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, тулгуурт урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Агаарын шугамын тасралт, саатлын бууралт | Суурь түвшин байхгүй | Агаарын шугамын тасралт, саатлын зөрчлийг арилгуулж, шугамын найдвартай ажиллагааг хангуулна. | II-III улирал | ЭХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 84. | Эрчим хүчний үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын өвөлжилтийн бэлэн байдал хангагдсан эсэхэд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | 2021 оны хяналт шалгалтаар дулааны эрчим хүч (дулаан, цахилгаан) үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөлтэй 98 аж ахуйн нэгж байгууллагад 232 зөрчил илрүүлж 56 зөрчлийг газар дээр нь арилгасан. Хууль тогтоомжийн хэрэгжилт 76 хувь. | Шалгалтаар илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулж, улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулна. | III-IV улирал | ЭХЯ, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 85. | Шинээр баригдаж буй орон сууцны барилгуудад суурилуулж буй ус, дулаан, цахилгааны хэмжих хэрэгслүүдийн хэмжлийн нэгдмэл байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | - | Шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийн түвшнийг 10.0 хувиар нэмэгдүүлсэн байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Объектын эрсдэлийн түвшнийг бууруулсан байна. | II-III улирал | Стандарт, хэмжил зүйн газар, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын байгууллага, нэгж |
| 86. | Үнэт металл, эрдэнийн чулуугаар хийсэн эдлэл худалдан борлуулдаг худалдааны төв болон дэлгүүр (лангуу,түрээслэгч)-т урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, | Сорьцын хяналтаар: 15 худалдааны төв, дэлгүүр шалгалтад 129666 бүтээгдэхүүнийг хамруулж, 5965 зөрчил илрүүлснээс 100 хувь арилгуулсан. Илэрсэн зөрчилд | 15-аас доошгүй худалдааны төв, дэлгүүрийн 130000 бүтээгдэхүүнийг хамруулна. Улсын байцаагчийн | II-III улирал | Стандарт, хэмжил зүйн газар, аймаг, нийслэлийн Хяналт шалгалтын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | зөрчлийг арилгах албан шаардлага өгч шийдвэрлэсэн. 5 худалдааны төв, дэлгүүрийн эрсдэлийн түвшинг бууруулсан. | гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. Илэрсэн зөрчлийг 80 хувь арилгуулсан байна. | | байгууллага, нэгж |
| **Төлөвлөгөөт бус шалгалт** | | | | | | | |
| 87. | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | - | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт (хувь), Зөрчил арилгалт (хувь) | 2022 онд төлөвлөгөөт бус шалгалтад 15214 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулсан байна. | Өргөдөл, гомдлыг хууль, журмын дагуу 100 хувь шийдвэрлэж, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна. | I-IV улирал | Хяналт шалгалтын байгууллагууд |
| **Гүйцэтгэлийн хяналт шалгалт** | | | | | | | |
| 88. | Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх | - | Албан шаардлагын биелэлт (тоо, хувь), Арилгуулсан зөрчлийн (тоо, хувь), Эрсдэлийн түвшин буурсан объектын (тоо, хувь) | 2022 онд төлөвлөгөөт бус шалгалт, урьдчилан сэргийлэх шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар нийт 17579 заалттай 3622 албан шаардлага хүргүүлсний 76.6 хувь биелэгдсэн. | Албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг дүгнэж, тайлагнасан байна. | II-IV улирал | Хяналт шалгалтын байгууллагууд |

----o0o----